



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2013 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/316

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 2013 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-ын 1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Эрдэнэчимэг/, хэрэгжилтэд тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ хийн дүнг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Лувсанжамц/-т даалгасугай.



Л.ГАНТӨМӨР

902145



Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2013 оны 08 дугаар сарын 19 өдрийн
4/316 дугаар тушаалын хавсралт

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦУУЛАХ ОЮУТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Сургалтын төрийн сангийн зээлээр дэлхийн шилдэг их сургуульд бакалаврын зэргийн өдрийн сургалтад суралцах оюутныг бүртгэх, сонгон шалгаруулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах мэргэжлийн чиглэл, суралцуулах оюутны тоог тухайн оны 2 дугаар сард багтаан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын /цаашид “яам” гэх/ цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.
- 1.3. Дэлхийн шилдэг их сургуульд сургалтын төрийн сангийн зээлээр суралцах хүсэлтэй иргэнийг сонгон шалгаруулалт болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө яамны цахим хуудсаар дамжуулан зарлаж бүртгэнэ.

Хоёр. Бүртгэл, түүнд тавигдах шаардлага

- 2.1. Энэ журмын 1.1-д заасан сургалтын зээлд хамрагдах хүсэлтийг дараах болзол, шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн гаргана.
 - 2.1.1 Засгийн газраас баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-ын 1.3 дахь хэсэгт заасан жагсаалтын эхний 20-д багтсан их сургуульд мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр бакалаврын зэргийн үндсэн ангид суралцах урилга авсан иргэн;
 - 2.1.2 Засгийн газраас баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-ын 1.3 дахь хэсэгт заасан жагсаалтын 21-100-д багтсан их сургуульд Засгийн газраас баталсан мэргэжлийн чиглэлээр бакалаврын зэргийн үндсэн ангид суралцах урилга авсан иргэн;
- 2.2. Иргэн бүртгүүлэхдээ дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:
 - 2.2.1. өргөдөл /яамнаас гаргасан маягтын дагуу/;
 - 2.2.2. суралцах зорилго, өөрийгөө бэлтгэсэн байдал болон энэ сургалтын зээлд хамрагдах шаардлагатайг тайлбарласан үндэслэл, суралцах болон төгсөөд хийх ажлын тухай төсөөлөл, суралцахад шаардагдах дэмжлэг, нөхцөлийг тодорхой илэрхийлсэн эссе (2000 үгэнд багтаасан байх);
 - 2.2.3. энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан их сургуулийн үндсэн ангид суралцуулах тухай албан ёсны захидлын эх хувь болон түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
 - 2.2.4. одоо суралцаж буй сургуулийн тодорхойлолт, дүнгийн жагсаалтын эх хувь;
 - 2.2.5. бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дүнгийн хавсралтын эх хувь болон түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

- 2.2.6. бүртгэлийн хураамж;
2.2.7. магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн тодорхойлолт, ерөнхий шинжилгээний бичиг.

Гурав. Сонгон шалгаруулалт

- 3.1. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан комисс сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүний 60-аас доошгүй хувь нь дээд боловсролын сургалтын байгууллагын мэргэшсэн багш нар байна.
- 3.2. Сонгон шалгаруулалтыг баримт бичигт шинжилгээ хийх, ярилцлага хийх гэсэн 2 үе шаттайгаар зохион байгуулж, 100 хүртэлх оноогоор дүгнэнэ. Ярилцлагыг онлайнгаар хийж болно.
- 3.3. Комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.3.1. Комиссын гишүүн бүр баримт бичигт шинжилгээ хийж, энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан байдал, 2.2-т тусгасан баримт бичгийн чанарт 30 хүртэл онооны үнэлгээ өгнө.
- 3.3.2. Энэ журмын 2.2.2.-т заасан суралцах зорилго, өөрийгөө бэлтгэсэн байдал, суралцах болон төгсөөд хийх ажлын тухай төсөөллийн талаар дагуу иргэнтэй ярилцлага хийж 70 хүртэл онооны үнэлгээ өгнө.
- 3.3.3. Комиссын гишүүдийн нийлбэр онооны дунджаар тухайн иргэний шалгалтын нийт оноог гарган дүгнэнэ.
- 3.3.4. Комисс энэ журмын 1.2-т заасан мэргэжлийн чиглэл тус бүрээр хяналтын тоонд багтаан шалгаруулалтад 70-аас дээш оноо авч тэнцсэн иргэдийн жагсаалтыг гаргана. Иргэдийн оноо тэнцвэл одоо суралцаж буй сурлагын голч дүнг харгалзах бөгөөд уг оноо дахин тэнцсэн тохиолдолд бүрэн дунд боловсролын үнэмлэхийн дундаж дүнг харгалзана.
- 3.3.5. Тэнцсэн иргэдийн жагсаалтад комиссын дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсгээ зурж албажуулан яаманд ирүүлнэ.
- 3.4. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шалгаруулалтын дүнг үндэслэн оюутан суралцуулах тухай шийдвэрийг гаргана.

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. Иргэн нь энэ журмын 2-т заасан болзол, шаардлагыг хангаагүй, баримт бичгээ дутуу эсвэл хуурамчаар бүрдүүлсэн болон сонгон шалгаруулалтын дэг зөрчих, бүртгэл, шалгаруулалтын үед тавьсан бусад шаардлагыг биелүүлээгүй бол сонгон шалгаруулалтад оруулахгүй.
- 4.2. Энэ журмыг хэрэгжүүлэх явцад гарсан аливаа маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.